

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 7 ХОНОГИЙН ТАЙЛАН
/2022.05.02-2022.05.06/

2022.05.06

Дархан хот

№	Ажлын чиглэл	Гүйцэтгэлийн үр дүн
Барилга хот байгуулалтын хэлтэс		
1	Барилгын чиглэл	<ul style="list-style-type: none"> • Засгийн газрын 213-р тогтоолын дагуу 4 барилга байгууламжид барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг олгосон. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Дархан сум, 11-р баг “Стронгер” ХХК-ний 156 айлын орон сууц - Дархан сум, 10-р баг, “Монбамбай” ХХК-ний 45 айлын орон сууц - Дархан сум, 9-р баг, “ЦЦТО” ХХК-ний 54 айлын орон сууц - Дархан сумын 5,6,7-р багийн ТК27-ТК39 худгийн хооронд дулааны шугам • Иргэн Д.Баярсайханы Дархан сумын 10-р багт орон сууцны барилга эхлүүлэх зөвшөөрөл хүссэний дагуу барилгын техникийн бичиг баримтыг хянаж үзэхэд газрын зориулалт үйлчилгээний зориулалттай байсан тул боломжгүй тухай албан бичгийг хүргүүлсэн. • Улсын бүртгэлийн хэлтсээс ирүүлсэн хүсэлтийн дагуу 2013 онд ашиглалтад орсон “Минж проперти” ХХК-ний нийтийн орон сууцны дулааны зогсоолын тоог баталгаажуулан албан бичгээр хүргүүлсэн. • Уур амьсгал, гамшигт тэсвэртэй орон сууцжуулах техникийн туслалцааны ажлыг эхлүүлэх, “Орлогод нийцсэн орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлж, санхүүгийн салбарыг сайжруулах” техникийн туслалцааны хүрээнд Монгол банкнаас ирсэн төлөөллүүдэд холбогдох мэдээллийг өгч ажилласан.
2	Хот байгуулалтын кадастр, зураг төсөл магадлал	<ul style="list-style-type: none"> - Ногоон Дархан 2032 хөтөлбөрийн мод тарих байршлын зураг гаргах - Ногоон Дархан 2032 макетын ажил - Байршлын зураг 3 - Архитектур төлөвлөлтийн даалгавар 4-г судлан боловсруулсан - Мал бүхий иргэдийн газар олголтын зураг <p><i>Нэгж талбарын нөхөн бүрдүүлэлтийн буюу нэмэлт ажлын чиглэлээр:</i></p> <ul style="list-style-type: none"> - 16 хүний өргөдлийг нэгж талбартай нь холбож шинэчилсэн бүртгэлд бүрэн хамруулсан. - Өдөр бүр шинэчилсэн бүртгэлд хамрагдахаар ирсэн иргэний мэдээллийг шалгаж, цахим бүртгэлд хамрагдах шаардлагатай 9 иргэний өргөдлийг хүлээн авч мэдээлэл зөвлөгөө өгч ажилласан.
3	Инженерийн дэд бүтэц	<ul style="list-style-type: none"> ✓ Туслах аж ахуйн байгуулах газар олголт хийхтэй холбогдуулан газрыг тэмдэглэх шохой асгах ажилж 3 өдөр гүйцэтгэсэн
4	Барилгын материал чиглэлээр	<ul style="list-style-type: none"> ✓ Дархан сумын мал бүхий иргэдийг төвөөс гадагш нэг цэгт төвлөрүүлж Хонгор сумын 1-р баг Талын толгой төмсний бригад орчимд 11.2 га буюу 78 айл өрх, мал бүхий иргэдэд шинээр газар эзэмшүүлэх, газрын байршил, хил заагийг газар дээр нь шохойгоор тэмдэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллаж байна. Мөн гахайн аж ахуйн эрхэлж буй 33 иргэн, 14 ААНБ-ууд 14.8 га газар Орхон сумын Ноёнхонгорт төлөвлөж олгохоор бэлтгэл ажлыг хангаад байна. ✓ Тус ажлын хүрээнд хамтран ажилласан Силикат ХК, Дархан Эрдэс Шохойт Шийр ХХК, Сутайн үхэр чулуут ХХК, Тулгат шийр ХХК-иудад бидний ажилд тусалж, дэмжиж аймаг, орон нутгийн хөгжилд хувь нэмрээ оруулсан ✓ 2022.05.02-ны өдөр Барилгын материал үйлдвэрлэгчдийн холбооны гишүүний хамт барилгын материалын тусгай

		зөвшөөрөл сунгуулах хүсэлт гаргасан ААНБ-ын хүсэлтээр үйлдвэрлэлийн байдал, тоног төхөөрөмжийн хэвийн байдал, ажиллагсдын тогтвор суурьшил, хөдөлмөр хамгаалал, нийгмийн баталгаа, бүтээгдэхүүний шинжилгээний бичиг зэргийг нүдээр үзэн танилцаж хугацааг хэрхэн сунгах тухай шийдвэрлэх баримт бичгийг шалгав.
Газрын удирдлагын хэлтэс		
1	Суурь судалгаа, газрын мониторинг	<ul style="list-style-type: none"> ✓ Захиалгат хянан баталгааны мэдэгдэх хуудас 4 нэгж талбарт үүсгэв. ✓ Захиалгат хянан баталгааны 7 тайлан баталгаажуулж 2 тайланг хянаж буцаасан. ✓ Цахим гэрээ гэрчилгээг 10 нэгж талбарт үүсгэв. ✓ 31 дүгээр хорооллын 5 нэгж талбарт газар эзэмших гэрчилгээг шинэчилж мэдээллийн санд хаягийг зөв болгож засварлав. ✓ Мөн газар өмчлөөгүй гэсэн лавлагааг 5 иргэнд гаргаж өгч үйлчилсэн.
2	Газар зохион байгуулалт, төлөвлөлт, өмчлөл	<ul style="list-style-type: none"> • Аймгийн Цагдаагийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар болон Прокурорын газарт шалгагдаж байгаа иргэн, хуутгээдийн нийт 8 албан бичгийн лавлагааг газрын кадастрын мэдээллийн санаас шүүж хариуг хүргүүлсэн. • Эцэг эхийн зөвлөл нь “Гэр бүлийн өдөр” -ийг угтан аймгийн Музей газартай хамтран зохион байгуулахаар төлөвлөгөө боловсруулан ажилласан.
4	Геодези, зураг зүйн чиглэл	<p>Хаягийн зургийн дагуу 8 иргэн, 2 аж ахуйн нэгжийн эзэмшлийн газар, үл хөдлөх эд хөрөнгөд хаяг дугаар олгосон. Шинээр үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ авахаар /хувийн сууц, гараж, барилга байгууламж/ хэмжилт хийлгэсэн 10 иргэн, 2 аж ахуйн нэгжийн материалыг хүлээн авч мэдээллийн санд оруулж кадастрын зураг гаргасан.</p> <ul style="list-style-type: none"> • Өмчлөх эрхээ бусдад шилжүүлэх хүсэлтээ цахимаар ирүүлсэн 6 иргэний материалыг хянаж өмчлөх эрхийг шилжүүлсэн. • Геодези, зураг зүй, кадастрын зураглалын ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй “Гео од” ХХК-ний хийж гүйцэтгэсэн ”Сигма Эс” ХХК-ны 25-н айлын орон сууцны барилгын гүйцэтгэлийн ажлыг шалгаж хүлээн авсан. • Орхон сумын нутаг дэвсгэрт гахай шувууны аж ахуй эрхлэх иргэн аж ахуйн нэгжид олгох газрын улаан шугамыг тавьж тэмдэгжүүлэх ажлыг хийж гүйцэтгэхэд оролцсон. Нийт 190 солбицолыг газарт шилжүүлж 47 нэгж талбарыг шохой асгаж тэмдэгжүүлсэн. • Морин хуур толгой дээр байгуулах ногоон байгууламжийн хашааны улаан шугамыг тавьж НААҮГ-т хүлээлгэн өглөө. /12
Захиргаа удирдлага		
1	Хүний нөөц, хууль эрх зүйн чиглэл	<p>Сургалт:</p> <ul style="list-style-type: none"> • ТАЗөвлөлийн 7:4:10, Удирдлагын академийн багш Г.Жаргал /Док, Дэд пр/ “Төрийн албан хаагчийн ур чадварын түвшин, ёс зүйн үзэл, ёс суртахууны төлөвшил” сэдэвт цахим сургалтад байгууллагын 4 албан хаагч хамрагдсан.
2	Мэдээллийн технологи, нярав	<p>Мэдээлэл: 70376471 нээлттэй утсаар 12 иргэн, байгууллагын Facebook хуудсанд ирсэн 14 иргэн, ААНБ-ын асуултанд хариулт өгөв.</p> <p>Мэдээлэл технологийн чиглэлээр: Байгууллагын цахим хуудсанд байгууллагын 4-р сарын 1, 2, 3, 4-р долоо хоногийн болон 4-р сарын тайланг оруулав. Байгууллагын цахим хуудас болон Фэйсбүүк хуудсан дээр Дархан-Уул аймагт баригдаж буй барилгуудын үнийн мэдээг байрлуулав.</p> <p>Нярав: 10 ширхэг Нэгж талбарын хувийн хэрэг нугалж мэргэжилтнүүдэд олгоход бэлтгэв. Газрын удирдлагын хэлтсийн</p>

		мэргэжилтнүүдэд 3 ширхэг нэгж талбарын хувийн хэргийн хавтас олгож, кадастрын мэдээллийн санд өөрчлөлт оруулсны төлбөрийн баримт 12 ширхэгийг хүлээж авч бүртгэв.
--	--	---

Тайлан боловсруулсан:

Захиргаа, хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Б.Золбаясах

Хянасан:

Газрын удирдлагын хэлтсийн дарга

Г.Нямдорж